

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

ЦАХИМ БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Энэхүү “Цахим үйлчилгээний гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г, нэг талаас Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Их Эзэн Чингис хааны талбай гудамж 8/1 , Сити Тауэр 18 давхар 1803 тоот хаягт байрлах “Гүүдсек” ҮЦК ХХК /цаашид “ҮЦК” гэх/ нөгөө талаас гэрээ байгуулж үйлчилгээ авахаар хүсэлт ирүүлэн бүртгүүлсэн Монгол улсын иргэн /цаашид “Харилцагч” гэх/ нар /цаашид хамтад нь “талууд” гэх) Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн, дараах нөхцөлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээ нь ҮЦК-аас нь цахим хэлбэрээр үйлчилгээ авах эрхийг Харилцагчид олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээнд дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1. Үнэт цаасны компани гэж Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авсан “Гүүдсек ҮЦК” ХХК-г;
 - 1.2.2. Харилцагч гэж “Гүүдсек ҮЦК” ХХК-ийн www.goodsec.mn-д харилцагчийн бүртгэл үүсгэж, үнэт цаасны данс нээлгэх, дансаа хянах эрх бүхий харилцагчийг таних ажиллагаа бүрэн хийгдэж, холбогдох гэрээ байгуулсан харилцагчийг;
 - 1.2.3. Цахим үйлчилгээ гэж Харилцагчид www.goodsec.mn сайтаар дамжуулан өөрийн үнэт цаасны данс нээх болон нээгдсэн үнэт цаасны дансаа удирдах үйлчилгээг;
 - 1.2.4. Харилцагчийн данс гэж Харилцагчид www.goodsec.mn сайтаар дамжуулан программд ҮЦК-ийн системчилсэний дагуу дугаарлагдаж, харилцагчид оноогдсон дахин давтагдашгүй дугаарыг;
 - 1.2.5. Бүртгэлгүй харилцагч гэж www.goodsec.mn сайтад бүртгэлгүй эсхүл бүртгүүлсэн хэдий ч мэдээлэл бүрэн орж баталгаажуулаагүй харилцагчийг;
 - 1.2.6. Харилцагчийг таних үйл ажиллагаа гэж холбогдох хууль тогтоомж болон ҮЦК-ийн “Харилцагчийг таних үйл ажиллагааны журам”-д тусгагдсан үйл ажиллагааг;
 - 1.2.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /цаашид “ҮЦТХТ” гэх/ гэж Үнэт цаасны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийг.

ХОЁР: ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Цахим үйлчилгээг www.goodsec.mn сайтаар дамжуулан хийж гүйцэтгэнэ.
- 2.2. Харилцагчийн www.goodsec.mn сайтад ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг харилцагч бүрэн хариуцна.
- 2.3. Харилцагч 7 хоногийн бүх өдрүүдэд 24 цагийн турш шаардлагатай үедээ www.goodsec.mn сайтыг ашиглан дараах үйлдлийг хийх эрхтэй байна. Үүнд:
 - 2.3.1. Дансны үлдэгдэл болон хуулга харах шалгах;
 - 2.3.2. Арилжааны захиалга өгөх;
 - 2.3.3. Арилжааны үнэ ханшын мэдээллийг харах;

- 2.4. Харилцагчийн нэг удаагийн авах болон зарах захиалгын дээд хэмжээ 3,000,000 / гурван сая/ төгрөг байна.
- 2.5. ҮЦК нь арилжааны захиалгыг дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Хөрөнгийн биржийн арилжааны системд шивж оруулна. Үүнд:
 - 2.5.1. Харилцагчийн данс ҮЦГХТ-д бүртгэгдэж нээгдсэн байх;
 - 2.5.2. Харилцагчийн захиалга нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;
 - 2.5.3. Авах захиалга өгөхийг өмнө шаардлагатай мөнгөн хөрөнгийн арилжааны төлбөр тооцооны дансанд харилцагч өөрийн нэр дээр байршуулсан байх;
 - 2.5.4. ҮЦК-аас тавих бусад шаардлагуудыг хангасан байх.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦООНЫ НӨХЦӨЛ БОЛОН

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ, ХУРААМЖ

- 3.1. Цахим үйлчилгээний хураамж нь тогтомол дүнгээр илэрхийлэгдэнэ. Шимтгэлийн хэмжээг ҮЦК нь үйлчилгээний төрөл тус бүрт зориулан тогтоож, өөрчлөлт орсон тухай бүр ажлын 3 хоногт багтаан олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлж байна. Үйлчилгээний хураамж нь дараах төрөлтэй байна. Үүнд:
 - 3.1.1. Цахимаар хувьцааны данс нээх үйлчилгээний хураамж /гэрээний хавсралт №1/;
 - 3.1.2. Арилжааны зуучлалын шимтгэл /гэрээний хавсралт №1/;
 - 3.1.3. Харилцагчдад ногдол ашиг олгуулсаны шимтгэл /гэрээний хавсралт №1/;
 - 3.1.4. Нэмэлт тусгай үйлчилгээний шимтгэл.
- 3.2. ҮЦК нь гэрээний 3.1.2, 3.1.3, 3.1.4-т заасан шимтгэл хураамжуудыг арилжааны төлбөр тооцооны данс дах харилцагчийн нэр дээр бүртгэгдсэн мөнгөн хөрөнгөөс саадгүйгээр суутган авна.
- 3.3. Харилцагч нь гэрээний 3.1.1-д заасан хураамжийг арилжааны банкууд дах ҮЦК-ийн харилцах данс /хавсралт №2/-д урдчилан байршуулсан байна.
- 3.4. www.goodsec.mn ашиглан хийгдсэн үйлчилгээ, шимтгэл хураамжийн гүйлгээ, бусад нэмэлт мэдээллийг бүртгүүлсэн цахим шуулангаар, утсаар дамжуулан харилцагчид мэдэгдэж болно.
- 3.5. Гэрээний 3.1.2-т заасан шимтгэлд арилжаатай холбоотой бусад байгууллагуудын шимтгэл хураамж багтсан болно
- 3.6. Шимтгэл, хураамж болон үйлчилгээний шимтгэлүүдийг ҮЦК дангаар өөрчлөх эрхтэй бөгөөд эдгээр өөрчлөлтүүд нь холбогдох хууль тогтоомж, эрх бүхий этгээдээс баталсан журамд нийцсэн харилцагчид хохиролгүй байна.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Харилцагч дараах эрхтэй. Үүнд:
 - 4.1.1. Цахим үйлчилгээг цаг хугацаа орон зайнаас үл хамааран авах;
 - 4.1.2. Үйлчилгээтэй хобоотой санал гомдолоо шийдвэрлүүлэх;
 - 4.1.3. Цахим үйлчилгээний эрхээ цуцлуулах;
 - 4.1.4. Өөрт холбоотой мэдээллийн нууцлалыг хангуулах;
 - 4.1.5. Өөрийн данс хуулга, мэдээллийг баталгаажуулан гаргуулж авах;

- 4.1.6. Үйлчилгээний болон системийн өөрчлөлттэй холбоотой мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах;
- 4.1.7. www.goodsec.mn нэвтрэх нэр, нууц үгийг ҮЦК-аас дахин гаргуулж авах;
- 4.1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг ҮЦК-д шаардах;
- 4.1.9. Хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.
- 4.2. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.1. Харилцагчийн мэдээллийг үнэн зөв өгөх;
 - 4.2.2. www.goodsec.mn нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх;
 - 4.2.3. www.goodsec.mn нэвтрэх нэр, нууц үгийг бусдад алдсан тохиолдолд яаралтай өөрчлөх, ҮЦК-д мэдэгдэх;
 - 4.2.4. Арилжааны захиалгыг холбогдох дүрэм журамд нийцүүлж захиалах;
 - 4.2.5. Энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргийг хүлээнэ.
- 4.3. Өөрийн буруутай үйлдлээс үүдсэн болон гэрээний 4.2.2,4.2.3,4.2.4-т заасныг зөрчсөний улмаас гарсан авилаа хохирлыг Харилцагч бүрэн хариуцна.
- 4.4. ББСБ дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 4.4.1. Харилцагчийн хууль тогтоомж зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарсан хохирлыг барагдуулахыг харилцагчаас шаардах, ҮЦК-д учирсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэх гаргах;
 - 4.4.2. Харилцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг өөрийн санаачлагаар цуцлах;
 - 4.4.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулах, харилцагчаас нэмэлт мэдээлэл шаардах;
 - 4.4.4. Эрх бүхий байгууллагаас шаардлага ирүүлсэн тохиолдолд Харилцагчийн мэдээллийг хуульд заасан хэмжээгээр ил болгох;
 - 4.4.5. Хууль, тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.
- 4.5. ҮЦК нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 4.5.1. Харилцагчид цахим үйлчилгээтэй холбоотой заавар зөвлөгөө өгөх;
 - 4.5.2. Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр дансанд орсон өөрчлөлтийг Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр эрх бүхий байгууллагаар шалгуулах;
 - 4.5.3. Харилцагчийг үнэн зөв мэдээллээр хангах;
 - 4.5.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох, бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөх;
 - 4.5.5. Гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.

ТАВ.БАТАЛГАА

- 5.1. Харилцагч энэхүү гэрээг байгуулахдаа дараахь баталгааг гаргасан болно. Үүнд:
 - 5.1.1. Гэрээний зүйл заалтуудтай танилцаж үйлчилгээний нөхцөлийг бүрэн зөвшөөрсөн;
 - 5.1.2. ҮЦК болон гуравдагч этгээдийг хохироох зорилгоор санаатайгаар гэрээ байгуулаагүй;
- 5.2. ҮЦК нь харилцагчид үзүүлэх үйлчилгээний тогтвортой байдлын хангах баталгааг гаргана.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Гэрээг Монгол хэлээр үйлдэх бөгөөд ҮЦК нь Харилцагчийн цахим шуудангийн хаягаар гэрээг илгээнэ. Харилцагч гэрээг цахим шуудандаа хүлээн авсан нь гэрээг бичгээр байгуулсантай адилтган үзэх нөхцөл болно.
- 6.2. Энхүү гэрээ нь Харилцагч хүлээн зөвшөөрөх сонголтыг дарж, ҮЦК-аас баталгаажуулсан хариу илгээснээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 6.3. Талууд харилцан тохиролцсоны дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 6.4. Талууд гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэхийг хориглоно.